

2008.05.19

Дугаар 121

”Гермес центр” ХК-ийн анхдагч зах
зээлийн арилжааг үргэлжлүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7 дэх заалт болон “Гермес центр” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2008 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн “Хүсэлт гаргах тухай” 02-71 тоот албан бичгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Гермес центр” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааг 2008 оны 5 дугаар сарын 20-ний өдрөөс 23-ний өдрийг хүртэл өдөр бүр 12 цагаас 12 цаг 30 минутын хооронд үргэлжлүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Анхдагч зах зээлийн арилжаа явагдах 2008 оны 5 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд нэг хөрөнгө оруулагчийн худалдан авах хувьцааны дээд хэмжээ 50.0 сая төгрөг хүртэл байх, 22, 23-ны өдрүүдэд нэг хөрөнгө оруулагчийн худалдан авах дээд хэмжээнд хязгаар тогтоохгүй байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоолын 2-т заасан өдрүүдэд хийгдэх арилжааны хувьд хувьцаа худалдан авах захиалгын эрэлт нь нийлүүлэлтээс хэтэрсэн тохиолдолд захиалга өгсөн харилцагчдад хувь тэнцүүлэхгүйгээр цаг хугацааны ахлах дарааллаар анхдагч зах зээлийн арилжааг хийж дуусгахаар тогтоосугай.

4. Энэ тогтоолд заасны дагуу арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог хийж гүйцэтгэх, үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлд бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р. Содхүү/-д, “Үнэт цаас, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХУУЛБАР ҮНЭН:

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ